



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСЭГ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

(Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-001498)

(Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 2050374)

Хянасан:

Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын
ахлах мэргэжилтэн/

Биелэлтийг тайлагнасан: “ШАРЫН ГОЛ” ХК

Гүйцэтгэх захирал _____ / Б.Мэндсайхан /


Байгаль орчны мэргэжилтэн _____ / Б.Амангельд /

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Буянтын хөндийн адаг хэсэг”-ийн алтны шороон орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 250 км, Дархан хотоос 45 км, Шарын гол сумаас баруун тийш 2.6 км-т Шарын голын хөндий, Буянтын хөндийн адаг уулзвар орчмыг хамарсан байдаг.

MV-001498 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай төслийн талбай нь 1767.19 га.

Зураг-1. Төслийн талбайн байршилн тойм зураг



Хүснэгт 1. MV-001498 тоот талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	106° 27' 26.2"	49° 15' 31.91"	38	106° 26' 36.61"	49° 13' 43.44"	75	106° 28' 11.16"	49° 14' 0.58"
2	106° 27' 26.2"	49° 15' 14.91"	39	106° 26' 43.41"	49° 13' 43.36"	76	106° 28' 11.16"	49° 14' 4.58"
3	106° 28' 12.21"	49° 15' 14.91"	40	106° 26' 45.93"	49° 13' 41.37"	77	106° 28' 7.78"	49° 14' 4.64"
4	106° 28' 12.21"	49° 14' 42.91"	41	106° 26' 57.38"	49° 13' 39.41"	78	106° 28' 3.77"	49° 14' 1.11"
5	106° 28' 37.21"	49° 14' 42.91"	42	106° 27' 6.75"	49° 13' 39.24"	79	106° 28' 1.11"	49° 13' 55.48"
6	106° 28' 37.21"	49° 14' 15.71"	43	106° 27' 12.71"	49° 13' 40.84"	80	106° 27' 54.66"	49° 13' 53.26"
7	106° 28' 17.82"	49° 14' 15.94"	44	106° 27' 29.33"	49° 13' 41.05"	81	106° 27' 47.39"	49° 13' 47.27"
8	106° 28' 17.71"	49° 14' 11.91"	45	106° 27' 34.47"	49° 13' 38.67"	82	106° 27' 39.26"	49° 13' 45.99"
9	106° 28' 11.2"	49° 14' 11.91"	46	106° 27' 37.1"	49° 13' 38.72"	83	106° 27' 34.43"	49° 13' 43.19"
10	106° 28' 11.2"	49° 13' 36.92"	47	106° 27' 41.82"	49° 13' 42.47"	84	106° 27' 29.28"	49° 13' 46.38"

**БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

11	106° 28' 34.2"	49° 13' 36.92"	48	106° 27' 49.96"	49° 13' 39.28"	85	106° 27' 19.51"	49° 13' 44.82"
12	106° 28' 34.2"	49° 13' 5.91"	49	106° 28' 0.95"	49° 13' 36.61"	86	106° 27' 16.89"	49° 13' 45.92"
13	106° 27' 20.2"	49° 13' 5.91"	50	106° 28' 4.07"	49° 13' 34.73"	87	106° 27' 10.2"	49° 13' 45.32"
14	106° 27' 20.2"	49° 12' 34.92"	51	106° 28' 8.51"	49° 13' 34.06"	88	106° 27' 4.78"	49° 13' 42.96"
15	106° 26' 52.31"	49° 12' 34.92"	52	106° 28' 19.5"	49° 13' 23.37"	89	106° 27' 2.99"	49° 13' 44.22"
16	106° 26' 44.67"	49° 12' 36.97"	53	106° 28' 34.08"	49° 13' 23.81"	90	106° 26' 58.86"	49° 13' 43.4"
17	106° 26' 43.41"	49° 12' 36.98"	54	106° 28' 34.08"	49° 13' 27.6"	91	106° 26' 50.13"	49° 13' 44.66"
18	106° 26' 35.56"	49° 12' 34.92"	55	106° 28' 31.24"	49° 13' 28.14"	92	106° 26' 51.13"	49° 13' 47.09"
19	106° 26' 31.2"	49° 12' 34.92"	56	106° 28' 23.17"	49° 13' 28.21"	93	106° 26' 42.93"	49° 13' 49.41"
20	106° 26' 31.2"	49° 13' 6.92"	57	106° 28' 19.81"	49° 13' 30.79"	94	106° 26' 38.41"	49° 13' 47.94"
21	106° 25' 41.2"	49° 13' 6.92"	58	106° 28' 21.91"	49° 13' 33.35"	95	106° 26' 37.15"	49° 13' 49.51"
22	106° 25' 41.2"	49° 12' 34.92"	59	106° 28' 12.58"	49° 13' 36.88"	96	106° 26' 40.8"	49° 13' 51.98"
23	106° 25' 3.2"	49° 12' 34.92"	60	106° 28' 11.15"	49° 13' 36.88"	97	106° 26' 35.44"	49° 13' 58.79"
24	106° 25' 3.2"	49° 13' 8.92"	61	106° 28' 11.15"	49° 13' 37.44"	98	106° 26' 34.21"	49° 13' 59.3"
25	106° 23' 13.2"	49° 13' 8.92"	62	106° 28' 7.14"	49° 13' 38.96"	99	106° 26' 34.21"	49° 14' 13.91"
26	106° 23' 13.21"	49° 13' 41.92"	63	106° 28' 3.58"	49° 13' 40.88"	100	106° 26' 28.2"	49° 14' 13.91"
27	106° 23' 38.21"	49° 13' 41.92"	64	106° 27' 59.74"	49° 13' 40.95"	101	106° 26' 28.2"	49° 14' 44.92"
28	106° 23' 38.21"	49° 14' 13.91"	65	106° 27' 49.76"	49° 13' 43.74"	102	106° 26' 36.21"	49° 14' 44.92"
29	106° 26' 2.21"	49° 14' 13.91"	66	106° 27' 56.93"	49° 13' 49.45"	103	106° 26' 36.21"	49° 15' 6.92"
30	106° 26' 2.21"	49° 14' 4.91"	67	106° 28' 0.71"	49° 13' 50.45"	104	106° 26' 47.21"	49° 15' 6.92"
31	106° 26' 11.2"	49° 14' 4.91"	68	106° 28' 1.16"	49° 13' 51.32"	105	106° 26' 47.21"	49° 15' 16.91"
32	106° 26' 11.2"	49° 13' 54.91"	69	106° 28' 3.4"	49° 13' 51.71"	106	106° 27' 0.2"	49° 15' 16.91"
33	106° 26' 29.86"	49° 13' 54.91"	70	106° 28' 5.84"	49° 13' 52.36"	107	106° 27' 0.2"	49° 15' 28.52"
34	106° 26' 29.85"	49° 13' 54.82"	71	106° 28' 6.65"	49° 13' 53.03"	108	106° 27' 2.22"	49° 15' 28.51"
35	106° 26' 29.67"	49° 13' 54.45"	72	106° 28' 8.65"	49° 13' 55.77"	109	106° 27' 6.4"	49° 15' 31.08"
36	106° 26' 31.35"	49° 13' 50.12"	73	106° 28' 8.61"	49° 13' 58.34"	110	106° 27' 6.4"	49° 15' 31.91"
37	106° 26' 32.54"	49° 13' 46.97"	74	106° 28' 8.85"	49° 13' 59.46"			

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт


Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрийн технологийн заавар, горим, стандарт, аюулгүй ажиллагааны шаардлага, заавар дүрмийг ажиллагсад эзэмшүүлэх сургалтыг 2023 онд 7, 14, 30 хоногийн хугацаатайгаар тогтмол зохион байгуулсан бөгөөд сургалтыг ХАБ ажилтнууд болон БО мэргэжилтэн нар хариуцан ажилласан.

Болзошгүй аваар, ослын үед хэрэглэх анхны тусламжийн материал (өвчин намдаах эм, ариутгасан спирт, цэвэр боолт гэх мэт), ажилчдад амны хаалт олгож, гар ариутгагчийг ариун цэврийн өрөө, гал тогоо, ажлын байр болон оффист байрлуулан байнгын бэлэн байдалд байлгахыг уурхайн дарга хариуцан ажилласан.

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн холбогдох инженерүүд ажилласан.

“Усны бохирдол, хомсдол” сэдвээр ажилчдад сургалт зохион байгуулсан. Мэргэжлийн хүн урьж зохион байгуулсан нь ажилчдад байгаль дэлхийгээ хайрлах үзэл, усаа хэмнэх нь ямар чухал болохыг сайн ойлгосон үр дүнтэй сургалт болсон.

БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 2. 2018 онд MV-001498 тоот тусгай зөвшөөрлийн талбайд 2 давхцалын бүс байсан. **Улаан**-тусгай зөвшөөрлийн хил, **Цайвар цэнхэр**- БОАЖЯамны санд бүртгэлтэй голын энгийн хамгаалалтын бүсийн хил. **Тод цэнхэр**-Газар дээр нь шавь тавьж баталгаажуулсан жинхэнэ координат.

- Гол мөрний урсац бүрдэлдэх эх, усны сав бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.3, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2.1 заасан Засгийн газрын 289-р тогтоолоор батлагдсан усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй хэсэгчилсэн давхцалтай.
- Шарын гол сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 03 сарын 26-ны өдрийн 28 тоот тогтоолоор тогтоосон сумын хүн амын унд, ахуйн төвлөрсөн ус хангамжийн Буянтын эх үүсвэрийн худгуудын эх үүсвэр тус бүрээс 500 метрийн зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүстэй тус тус давхцалтай байсан.

БОАЖЯамны 2014 оны 04 сарын 03-ны өдрийн 066/2074 тоот албан тоотгоор манай байгууллагад онцгой хамгаалалтын бүстэй давхцал бүхий хэсэгт хасалт хийх бичгийг хүргүүлсэн боловч тухайн зургийн координат нь газар дээрх бодит голын гольдролоос зөрүүтэй байсан тул геодези зурагзүйн тусгай зөвшөөрөл бүхий “Гео-Арт инженеринг” ХХК-аар голын жинхэнэ голдиролд шавь тэмдэг тавиулах ажлыг зохион байгуулав. Үүний дагуу голын онцгой хамгаалалтын бүсийг MV-001498 тусгай зөвшөөрлийн талбайгаас хасалт хийж, энгийн хамгаалалтын 150м-т 5 талт гэрээг байгуулав. Ингэснээр талбайн булангийн цэгүүдэд өөрчлөлт орж 1826.18 га талбайгаас 58.99 га талбай хасагдаж нийт булангийн цэгийн тоо 110 болж өөрчлөгдөв.



ШАРЫН ГОЛ ХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2018.04.03 № 068/2014
танай _____-ны № _____-т

Онцгой хамгаалалтын бүсийн хилийн
зааг хүргүүлэх тухай.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших MV-001498 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь: Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, Шарын гол сумын унд ахуйн эх үүсвэрийн хамгаалалтын бүстэй тус тус давхцалтай байна.

2015 оны 2 сард нэмэлт өөрчлөлт орж батлагдсан “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”, Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоол 2.6 -д заасан дүгнэлт /тус яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 06/2620 тоот албан бичиг/ үндэслэн усны сан бүхий газрын 50 метрийн онцгой хамгаалалтын бүсийн хилийн цэсийг CD -нд бичиж хүргүүлэв.

Онцгой хамгаалалтын бүсийн хилийн заагийг тэмдэгжүүлэх ажлыг Геодези зураг зүйн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар онцгой хамгаалалтын бүсийн эргэлтийн цэгийг тогтоож, шав тэмдэгжүүлэн Усны сав газрын захиргааны төлөөлөл, орон нутгийн газрын даамал, байгаль хамгаалагч нарыг байлцуулан шав тэмдэгжүүлсэн тухай акт, тайлан үйлдэж орон нутгийн Засаг даргаар баталгаажуулан манай хэлтэст акт, тайланг ирүүлэн мэдээллийн санд бүртгүүлнэ үү.

Хэрэв голын голдрилд манай хэлтсээс өгсөн онцгой хамгаалалтын бүсээс зөрүүтэй байгаа тохиолдолд газар дээрх бодит нөхцөл байдалтай уялдуулан голын эргээс 50 метрийн онцгой хамгаалалтын бүсийг тогтоох ба шав тэмдэг тавьсан тухай акт, тайланд зөрүүтэй байсан талаар тусгахыг зөвлөж байна.

ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН
КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.БАТЗАЯА



Зураг 3. Лавлагаа

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН


📍 Кадастрын лавлагаа 📄 Мэдээ мэдээлэл 🔍 Холбоо барих хаяг 👤 Мэдээ оруулах

Кадастрын лавлагаа

Лавлагааны мэдээлэл

Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашигт малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.


Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-001498
Талбайн нэр	Шарын гол
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	1767.19
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Шарын гол
Аймаг, сум, сав газрын нэр	Дархан Уул аймаг Шарын гол сум, Хараа голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалтай
Давхцасан талаарх мэдээлэл	усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй 158.07 га давхцалтай



ТАНИХ ТЭМДЭГ

<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл</p> <ul style="list-style-type: none"> ▲ Ашиглалтын ▲ Хайгуулын <p>Засаг захиргааны хил</p> <ul style="list-style-type: none"> — Улсын хил — Аймгийн хил — Сумын хил ★ Аймгийн төв ■ Сумын төв <p>Тусгай хамгаалалттай газар нутаг</p> <ul style="list-style-type: none"> ■ Дархан цаазат газар ■ Байгалийн цогцолборт газар ■ Байгалийн нөөц газар ■ Дурсгалт газар 	<p>Хамгаалалтын бүсүүд</p> <ul style="list-style-type: none"> ■ Гол мөрний урсац бүрэлдэх эх ■ Ойн сан бүхий газар <p>Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс</p> <ul style="list-style-type: none"> ■ Онцгой хамгаалалтын бүс ■ Энгийн хамгаалалтын бүс <p>Ус хангамжийн эх үүсвэр</p> <ul style="list-style-type: none"> — Эрүүл ахуйн хориглолтын бүс — Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс — Тэжээгдлийн муж <p>Орон нутгийн усны хамгаалалтын бүс</p> <ul style="list-style-type: none"> — Орон нутгийн усны хамгаалалтын бүс
--	---

Масштаб 1:48976.0



БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 онд “Шарын гол” ХК нь Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт мониторинг зэрэг ажлуудад нийт 53.11 сая төгрөг зарцуулах төлөвлөгөөтэй байснаас 44.164 сая.төг зарцуулан ажилласан. Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд компанийн хэмжээнд тогтмол, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулдаг тул 2024 онд зарцуулсан зардлыг үйл ажиллагааны зардал болон нүүрсний хэсгийн тайлангын зардалд тусгасан.
2. Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын талбайн хэсэгт 2024 онд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийх талбай болон түрж тэгшлэх талбай нэмж талбай гараагүй тул 4.8 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж, явцын дунд гарсан зардлыг үйл ажиллагааны зардалд оруулсан мөн гарсан зардлыг техникийн нөхөн сэргээлтийн зарцуулан ажиллалаа.
3. Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын зардалаас Нүүрсний уурхайн Биологийн нөхөн сэргээлтийн 10 га талбайд Услагааний систем болон олон наст ургамал тарих ажилд зарцуулсан. 2024 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 4.8 га талбайд сул орон зайн дүүргэлт хийсэн.
4. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 1.0 га талбайд 5.0 сая төгрөг зарцуулан ДШГТ ӨХК-ийн цэвэр усны шугам дагуу түрж тэгшлэх ажлыг албан бичгийн дагуу хийж гүйцэтгэсэн.
5. Мөн дүйцүүлэн хамгаалах ажлын хэмжээний хүрээнд 1 га талбайг шимт хөрсөөр хучилт хийсэн.
6. “Тэрбум мод тарих” хөтөлбөрийн хүрээнд Компанийн хэмжээнд 2000 ш тарьцыг өмнөх жилд мод тарьсан хэсгийн ургалт, өсөлт муу хэсгүүдэд нөхөн тарилт хийсэн. Үүний 150 ш-ийг алтны уурхайн хэсгийн ажилчид суулгаж, ургалт өсөлтөд нь анхааран ажиллаж байна. Үүнд хамаарах зардлыг уурхайн үйл ажиллагааны зардалд тусгасан.
7. Түүх соёлын өвийг хамгаалах ажлын хүрээнд археологи, палентеологийн дурсгалт зүйлс илэрсэн талбайнуудад жилд нэг удаа БО хяналтын байцаагч, БХамгаалагч нартай үзлэг шалгалт хийдэг. Энэ ажлын хүрээнд 2024 онд ямар нэгэн түүх соёлын өвийг хамгаалсан, дурсгалт зүйлс илрээгүй тул тодорхой мөнгөн хөрөнгө зарцуулж, ямар нэгэн ажил хийгдээгүй.

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын хувьд тодорхой ажил хийгдээгүй, компанийн хэмжээнд хийгдсэн ажлууд тул нүүрсний БОМТ-ний биелэлтийн тайланд тусгасан.
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрс, агаар, усны шинжилгээнд 2024 онд 1.0 сая/төг зарцуулан ажилласан. Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй.
10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд 1.2 сая.төг зарцуулахаас байгаль орчны хяналт аудитын тайлан, усны дүгнэлт гаргуулах зэрэг ажилд 14.925 сая.төг зарцуулан ажилласан.
11. Нийгмийн хариуцлагын хүрээнд Шарын гол сумын засаг даргын тамгийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний дагуу зохих хэмжээний ажлуудийг хийж гүйцэтгэсэн. Үүнд зарцуулсан зардлыг компанийн үйл ажиллагааны зардалд тусгасан.

Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордыг бүрэн олборлосон талбайд нөхөн сэргээх ажлыг шат дараалалтайгаар хийж, уурхайн хаалтын ажилд бэлтгэх төлөвлөгөөтэй байгаа. ТЭЗҮ нь 2022 онд 5 жилийн хугацаатайгаар хийгдсэн.

1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ

Уур амьсгал

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт агаарын дундаж температур 1 дүгээр сард -30 градус, 7 дугаар сард +20 орчим хэмтэй байдаг. Дархан хотод агаарын үнэмлэхүй их температур +43 градус бол үнэмлэхүй бага температур -44 градус ба агаарын жилийн дундаж температур энэ бүс нутагт -1 градус юм. Хур тунадасны жилийн нийлбэр 300-400 мм. Тогтвортой цасан бүрхүүлтэй байх хоногийн тоо 150. Дархан-Уул аймагт нар гийгүүлэх хугацаа жилд 2700 цагаас бага байдаг. Өвлийн нэг өдөр нар гийгүүлэх хугацаа 5 цаг бол зуны нэг өдөр нар гийгүүлэх хугацаа 9 цаг тус тус байна. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт 1993 оноос хойш 15 жилд их хүйтрэлт 417 өдөр, их халуун 358 өдөр, хүчтэй салхи 41, шороон шуурга 119, цасан шуурга 179 удаа, аадар бороо 46, их цас 72 удаа тус тус орсон байна. Өвлийн улиралд цас бага орсны улмаас хавар хуурайшилт ихсэж, хүчтэй салхи, шороон шуургатай байх хоногийн тоо сүүлийн жилүүдэд өсөж байна /Оюунцэцэг, 2008/.

Газрын гадарга

Дархан Уул аймгийн Шарын гол сумын нутаг дэвсгэр нь Хангай Хэнтийн уулархаг их мужид хамрагдана. Хангай-Хэнтийн их мужийн уулс голдуу налуу хажуутай тул хөрсөн

бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцөлийг бий болгодог. Үүний ачаар хөрс харьцангуй зузаан бөгөөд ялзмаг болон тэжээлийн бодис ихтэй байна. Уулархаг гадаргын улмаас хөрсний бүсшил бий болж, ялангуяа уулсын ар, сүүдэр хажууд тод илэрнэ. Тус нутгийн уул нурууд далайн түвшнээс дээш дунджаар 1300-1400 м өндөр, харин тал хөндий хэсэгтээ далайн түвшнээс дээш 1100-1200 орчим метр өндөрт өргөгдсөн нь хээрийн судалгааны үр дүнд илэрсэн болно.

Мөн газрын гадарга уул үүсэх тектоник үйл явцад аажим орсон нь уулсын атираашил, хагарал бараг үгүй бөгөөд уулын орой мөлгөр байгаагаас илэрхий байна. Харин хур тунадасны усны үйл ажиллагаагаар идэгдэлд орсон гуу жалга цөөнгүй ажиглагдана.

Хөрсөн бүрхэвч

“Буянтын хөндийн адаг хэсэг”-ийн алтны шороон орд орчмын хээрийн судалгаагаар талбайн онцлогоос хамааруулан уулын хар хүрэн, уулын хүрэн, гуу жалгын хүрэн хөрсөнд тус бүр 1 зүсэлт хийсэн. Алтны шороон орд орчмын хөрс нь урвалын орчин шүлтлэг (ph 7.89-8.51) ялзмагийн агууламж 4-36%, элсэнцэр, элсэрхэг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй, бөөмөнцөр бүтэцтэй хөрс болно.

Ургамал

Монгол орны ургамлын аймгийг газарзүйн байрлал, онцлогоос хамааруулан 16 ангилсан байдаг. Энэхүү ангиллаар Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр тус ангиллаар ургамал газарзүйн 2 тойрогт хамаардаг ба үүнд Монгол-Дагуурын уулын ойт хээр болон Хэнтийн уулын тайгын тойрогт багтана. Эдгээр тойргуудад дараах зүйл ургамал тархсан байдаг. Дархан-уул аймгийн иргэд газар тариалан, бэлчээрийн чиглэлээр газар ашиглалт явуулдаг учир бэлчээрийн ургамал зонхилно. Бэлчээрийн бүрхцэд хамгийн олон тааралдах зүйл нь ширэг улалж байгаа ба нийт ургамлан бүрхэвчийн 30 орчим хувийг эзэлж байна. Үүний дараагаар хялгана, ишгүй гичгэнэ, дэрвээн хазаар өвс, агь зэрэг юм. Мөн хагд өвс, дэлхээ тогторгоно, бяцхан навчит болон нарийн навчит харгана тааралдана. Дархан сумын төвийн ойролцоох бэлчээрт ширэг улалж, бяцхан навчит болон нарийн навчит харгана, ишгүй болон имт гичгэнэ, агь шарилж ихээр ургаж бэлчээр доройтож малын шим тэжээлт ургамлууд ховордсон байна.

Шарын гол сумын нутгаар хялгана, ширэг улалж, хиаг, гандбадраа, дэрвээн хазаар өвс, ерхөг, шарилж, биелэг зэрэг ургамал ургаж Дархан уул, Олон хөтлийн орчим малчид ихээр зусаж, мал бэлчээрлэлтийн даац хэтэрснээс ургамал малд нэлээд идэгдсэн 5.5-8.1цн, Санжинт багийн Буянт орчмоор га-аас 9-10 цн ургацтай байгаа юм. Ер нь Дархан, Шарын

гол сумын нутагт мал бэлчээрлэх газар нутаг багатай тул зэргэлдээ сумдын нутагт орж зусдаг.

Усан орчин

Уст үе давхарга

Гидрогеологийн судалгаа явуулсан Шарын голын талбай нь Н.А.Мариновын ангиллаар Хангай-Хэнтий уулын атираат мужийн газрын доорх усны бүсэд хамаарна.

Судалгааны ажлын үр дүн, уст үеийн чулуулгийн бүтцийн онцлог байдлыг харгалзан үзэж дараах уст бүрдлийг ялгаж байна. Үүнд:

- Дээд дөрөвдөгч болон орчин үеийн голын гаралтай сэвсгэр хурдасны уст бүрдэл
- Шарын голын формацын нүүрс агуулагч чулуулгийн уст бүрдэл

Нүүрсний дээрх уст үе, давхаргын ан цавшилт нь гүн руугаа багасаж энэ уст үеийн ус нэвтрүүлэх чадвар мөн багасна. Нүүрсний дээрх үеийн дээд хэсэгт шүүрэлтийн итгэлцүүр 9.6-23 м/хоног байхад 100 м гүнд 3.5 м/хоног, 250 м-ийн гүнд 0.5м/хоног болж багасна (1968-1969 онуудад явуулсан гидрогеологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан)

Шарын голын уурхайн ашиглалтын явцад гарсан гидрогеологийн нөхцөлийн өөрчлөлт

Шарын голын нүүрсний ордыг 1960 онд нээж 1965 онд нүүрсний уурхай ашиглалтад орсон. Тус уурхай ашиглалтад орсноос хойш өнөөдрийн байдлаар 2500 м урттай, 1500 м өргөнтэй, 215 м гүнтэй одоогийн ил уурхай бий болжээ.

Анх уурхай ашиглалтад орох үед цагт 350м³ ус шүүрүүлдэг байсан бол өнөөгийн олборлолт явуулж байгаа уурхайн ашиглалтын албаны мэдээллээр 2013 онд хоногт 800 м³/хоног ус шүүрүүлдэг болсон байна.

1.2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын ашиглалтын одоогийн байдал болон ашиглалт явуулах хил хязгаар, ашиглах тоног төхөөрөмж зэргийг тооцон үзэхэд амьтны аймаг, ургамлын бүрхэвч, бэлчээрт үзүүлэх онцгой хортой нөлөөлөл байхгүй.

Үйлдвэрийн технологийн бүтэн цикл нь хөрс хуулалт, элс олборлон баяжуулах гэсэн үе шаттай явагддаг.

Технолгийн үе	Хийгдэх ажил	Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл
Уулын ажил	- Үүсмэл овоолгод хоосон чулуулгийн хуулалт хийх.	- Газрын эвдрэл, тоос хоосон чулуулгийн овоолго
	- Элс олборлолт	- Газрын эвдрэл, тоос

Хийгдэж буй уулын ажлын үйлчлэлээр байгаль орчинд голлон үзүүлэх нөлөөлөл нь хөрсний эвдрэл, овоолгоос хий салхины нөлөөгөөр үүсэх дэгдэмхий тоос нь ойр орчмын ургамлын бүрхэвчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Гэхдээ энэ нөлөөлөл нь салхины эрчим их, ургамлын бүрхэвч дахин сэргээгүй байгаа, сэргэж буй үе буюу 5-6 сарын хооронд идэвхтэй ажиглагддаг. /Уурхайн хөрс хуулалтын үеийн хөрсний шинжилгээний хариуг хавсаргав/.

Уурхайн байгаль орчинд шууд нөлөөлөл үзүүлэх тоног төхөөрөмжүүд болон, уурхайд ашиглагдаж байгаа барилга байгууламжийг дурдвал:

- Уурхайд ажиллаж байгаа, цаашид ажиллах тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн жилд ажилласан хугацаа:

№	Техник тоног төхөөрөмжийн нэр	Тоо, (Ажиллаж байгаа)	Тоо, (Цаашид ажиллах)	Жилд ажиллах хугацаа (сар)
1	Эксковатор	1	1	6
2	Бульдозер	1	1	5
3	Утгуурт ачигч	2	2	6
4	Автосамосвал	3	3	6
5	Үйлчилгээний машин	1	1	6
6	Усны машин	1	1	5

Техник тоног төхөөрөмжийн ажиллах хугацааг ерөнхий байдлаар харуулсан бөгөөд уулын ажлыг гүйцэтгэх, байгаль орчинд сөрөг нөлөө илүүтэй үзүүлэх экскаватор болон автосамосвалын ажиллах хугацаа нь 5 сар байгаа бөгөөд экскаватор нь хөрс хуулалт, элс олборлолтын үед 5, 6, 7, 8, 9, 10-р саруудад ажилласан.

Тиймээс хуурай халуун, хөрс хуулалтын үе давхцах 6, 7, 8-р саруудад уурхайгаас гарах тоос, агаарын бохирдлын хэмжээ бусад үеэс давах бөгөөд энэ үед уурхайн зам талбай, овоолгийг байнга услах, чийгтэй байлгах шаардлагатай байдаг.

Мөн тоног төхөөржүүдийн жилд хэрэглэх шатах тослох материал 274125.0 тн орчим болох бөгөөд үүнээс үүсэх хорт хий, утааны бохирдол агаарт нөлөөлнө. Өөр химийн бодис ашиглахгүй болно. Агаарын шинжилгээний хариуг хавсаргав.

1. Түр болон байнгын барилга, байгууламж:
 - Хоосон чулуулгийн овоолго
 - Уурхайн карьер
 - Цэвэр, тунаах, бохирын нуурын хамгаалалтын далан /ус зайлуулах суваг/

Мөн Байгаль орчныг хамгаалах, мэдээллийг түгээх, ажилчдын дунд сургалт явуулах чиглэлээр өнгөрсөн онуудад нилээд ажлыг зохион байгуулан ажилласан. Дархан-Уул аймаг, Шарын гол сумын БО-ны улсын байцаагч нартай албан ажлын чиглэлээр байнгын холбоотой ажилладаг бөгөөд цаг тухайд нь зөвлөгөө авч ажилладаг ба Шарын гол сумын БО улсын байцаагч байнгын хяналт тавин ажилладаг.

Манай компани нь Шарын голын уурхайн Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын талбайд байгаль хамгаалах чиглэлээр болон нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний асуудлыг шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд уг албан тушаалын ажил үүргийн хувиарыг тодотгон улирал тутамд байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилчдын дунд сургалт, зөвлөгөөн зохион байгуулсаар ирсэн.

Үүсэж болох аюулаас хамгаалах, ослын үед авах арга хэмжээний талаар тус компани нь иж бүрэн төлөвлөгөө боловсруулан ажилладаг бөгөөд уг аваар устгах төлөвлөгөө нь УУААнги, Сумын засаг даргын тамгын газар, Онцгой байдлын алба, Цагдаагийн тасаг, АМГТГ-ын Уул уурхайн хэлтэс, Эрүүл мэндийн төв, Дархан-Уул аймгийн байгаль орчны газар зэрэг төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцон ажиллаж ирлээ.

Аваар устгах төлөвлөгөөнд осол, аваар түүнийг устгах үед ажиллах албан тушаалтны эрх, үүргийг онцгойлон тусгаж өгсөн бөгөөд ослын үед ажиллах материаллаг

бааз, хэрхэн ажиллах талаарх чиглэл, арга замуудыг мөн тодорхойлсон. Осол аваар гаргахгүй байх зорилгоор онцгойлон анхаарч ажиллалаа.

“Баялаг Эко” ХХК-ийн гүйцэтгэсэн БОНБНУ-нд тусгагдсанаар орчны төлөв байдалд үзүүлэх төслийн гол сөрөг нөлөөллийн хэлбэрийг төслийн гол сөрөг нөлөөлөл, төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, зөвлөмж, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг хамгаалах чиглэлээр, техник хэрэгсэл тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зөвлөмж, болзошгүй аюул осолд уруйн үер, аянга, үйлдвэрийн болзошгүй осол гэсэн бүлэглэлд хуваан авч үзсэн байна.

Дээр өгүүлсэнээр болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс үзвэл уурхай ашиглах явцад хөрс, агаар, ургамал, геологийн тогтоц ихээхэн нөлөөлдөг байна.

Иймд сөрөг нөлөөлөлтэй тэмцэхийн тулд :

- а. Ачих, буулгах үеийн тоосжилтыг бууруулах,
 - б. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх,
- арга хэмжээнүүдийг цогцоор нь шийдвэрлэн ажиллаж байна.

Жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөтэй хавсран Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө гарган гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.

Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын талбайд байгаль орчинд тогтмол хийж хэрэгжүүлдэг арга хэмжээ:

Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордыг ашиглагдаж ирснээсээ хойш байгаль орчинд хандсан хяналт шинжилгээний ажлыг өөрийн мэдлийн хүрээнд болоод нутгийн байгаль орчины албатай байнга хамтран ажилласаар ирсэн.

Уурхай жил бүр байгаль орчинд ээлтэй, түүнийг арчлах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Нүүрсний уурхайгаас Буянтын хөндийн адаг хэсгийн алтны шороон орд хүртэл өөрийн талбай дотуур 3 км шороон замын цэвэрлэгээ, арчилгаа:
Уурхай өөрийн хөрөнгө санхүүжилтээр тээврийн болоод уурхайд хүрэх гол зам болох 3 км энэхүү замыг засаж сайжруулан, байнгын цэвэрлэгээ хамгаалалтад байлгадаг. Тээвэрлэлтийн явцад бороо хуртай үед эвдэрч цөмөрч хонхойсон, тээврийн хэрэгслийн байнгын явалтаар замын элэгдэл хонхор үүссэн газруудыг тэгшлэн замын хэвийн байдлыг хангах ажлыг тогтмол хийж байна. Энэ нь уурхайд хүрэх замыг зөвхөн нэг байлгаж олон салаа зам үүсэн хөрсний доройтол гарахаас сэргийлсэн хамгийн чухал үүрэгтэй ажил болж байдаг. Цаашид байнга хийж хэрэгжүүлнэ.
- Уст цэгийн хамгаалалт арчилгаа:

Уурхай ойр орчмын уст цэгүүдийг арчилах хамгаалах ажилд ихээхэн анхаарал хандуулдаг.

- Хяналт мониторинг:

Сумын байгаль хамгаалах албатай хамтран жил бүр уурхайн эдэлбэр газар болоод, хүрээлэн байгаа орчны судалгаа тандалтын ажлыг хамтран зохион байгуулж оролцдог. Энэ ажлын хүрээнд гарсан санал, зөвлөмжийн дагуу уурхайн үйл ажиллагаандаа анхаарч ажиллаж байна. Мөн уурхайн орчмын гэлтгүй бүс нутгийн хүрээнд сумын байгаль орчны албанаас хийж хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд дэмжигч, санхүүжүүлэгчээр ажиллаж байна.

1.3. 2024 ОНД ЯВУУЛСАН УУЛЫН АЖИЛ

Шарын гол ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд орших Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордод 2024 онд 120 мян.м³ хөрс хуулж, 66.8 мян.м³ элс олборлон баяжуулах төлөвлөгөөтэй байснаас хөрс хуулалт хийгдээгүй, 42.5 мян.м³ элс угаан баяжуулсан.

Хөрс хуулалтын ажил хийгдэгүй, элс олборлолтын хэмжээ нэмэгдсэн шалтгаан нь 05С, 03С, 08С, 07С үүсмэл овоолгийн хучаас хөрснөөс агуулга өгч байсан тул хаягдалгүйгээр бохирдолт ихтэйгээр олборлож, жилийн эцэст дундаж агуулга багасч металлын хэмжээ нэмэгдсэн.

Бохирын болон цэврийн нуурыг өмнөх онуудад ашигласан блокуудад байршуулсан байсан. Тиймээс бэлтгэл ажлын хүрээнд нуурын даланг сэргээх, баяжуулах төхөөрөмж суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Шарын гол ХК-ийн нүүрсний уурхайн шүүрлээс ус татах хоолойг мөн зарим хэсгийг нь зөөвөрлөх, шинээр холбох зэрэг усны хоолой татаж, уурхайгаас шүүрч байгаа усыг насосоор татаж, цэврийн нуураа дүүргэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2024 онд 05-р сараас 10-р сарын сүүл үе хүртэл уурхайн олборлолтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2024 онд 07С үүсмэл овоолгын 12.3 мян.м², 08С үүсмэл овоолгын 15.57 мян.м², 05С үүсмэл овоолгын 12.59 мян.м², 03С үүсмэл овоолгын 5,3 мян.м², талбайнуудад тус тус ашиглалтын үйл ажиллагааг явуулсан.

2024 онд шинээр эвдрэлд орсон талбай байхгүй.

ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:

Техникийн нөхөн сэргээлтийг дотоод овоолгоор 4.8 га, дотоод овоолгоор биологийн нөхөн сэргээлт 1.0 га, нийт 6,8 га талбайд хийхээр төлөвлөсөн боловч 2024 оны 6, 7, 8-р саруудад орсон их хэмжээний борооны улмаас уурхайн орчимд байх уулын ус жалга, суваг даган уурхайн ашиглагдсан карьер усанд автсан. Тиймээс төлөвлөгөөний дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж чадаагүй, хүндрэл үүссэн тул 2025 онд нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

2024 онд Нүүрсний уурхайн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд 20.0 мян м³ шимт хөрс бууц тээвэрлэж мөн хучилт хийж хэлбэржүүлсэн Алтны уурхай тус талбайд 150 ш мод тарьж усалгааны систем угсаралт хийж 6,7,8 саруудад бороогүй байсан ба 800 м труба татаж усалгаа тогтмол хийсэн

Мөн Дулаан шарын голын ирүүлсэн албан бичгийн дагуу 1.0 га талбайд 15.5 мян м³ шороогоор дүүргэлт хийж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:

Биологийн нөхөн сэргээлтийг 2024 оны 6, 7, 8-р саруудад орсон их хэмжээний борооны улмаас уурхайн орчимд байх уулын ус жалга, суваг даган уурхайн ашиглагдсан карьер усанд автсан. Тиймээс төлөвлөгөөний дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж чадаагүй, хүндрэл үүссэн тул 2025 онд нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн гүйцэтгэхээр төлөвлөөд байна .

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаар мандал:

Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 20108, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007.

Сөрөг нөлөөлөл:

Хөрс хуулалт, элс олборлолт, тээвэрлэлтийн үед тоос босож агаарыг бохирдуулж болзошгүй. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчныг хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

Ус, усан орчин:

Усны тухай хууль, Хаягдал бохир ус MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх

байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам.

Сөрөг нөлөөлөл:

- Түлш шатахуун, тослох материалууд бохир ус, химийн янз бүрийн бодисууд алдагдах, асгарах зэргээс үүдэн бага гүнд орших уст давхарга болон гадаргын усыг бохирдуулж болзошгүй.
- Ахуйн шингэн болон хатуу хог хаягдалдаа зөв менежмент явуулаагүйгээс болж газрын гадарга, гүний ус бактери болон химийн бохирдолд орж болзошгүй.

Хөрс, ургамал, газар:

Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийн түймрээс хамгаалах тухай, Ургамал хамгааллын тухай, Байгаль орчин, Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томьёо, тодорхойлолт MNS 5914 :2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915:2008, Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS5916:2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008, Байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008.

Сөрөг нөлөөлөл:

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтэцтэй холбоотойгоор газар овоолгод дарагдах, зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох
- Уурхайн малталт, дотоод замууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх
- Орд орчмын байгалийн гадаад үзэмж муудаж болзошгүй.
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.

2.1. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Ордыг ашиглах үед уурхай, үйлдвэрийн барилга байгууламж, тосгон, автомашины зам зэрэгт зориулсан тодорхой хэмжээний газар нутаг шаардлагатай болдог.

Эдгээр эдэлбэр газруудыг зөв ашиглан байгаль орчныг унаган төрөхөөр нь хадгалан хамгаалах ажлыг уурхай барьж байгуулах цагаас эхлэн хатуу хяналт тавьж ажиллаж байна.

Байгаль орчныг хамгаалах зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хөрсний овоолгыг зураг төслийг баримтлан байгуулж уурхайг ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээлт хийх;
- Уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэх үржил шимт хөрсний овоолгыг тусгай газар овоолж арчилах;
- Уурхайн орчинд тал бүр тийш олон салаа зам гаргахаас сэргийлж уурхайн траншейн замыг гол зам болон тосгон, баяжуулах үйлдвэр, овоолгын замтай холбоно.

Төсөл хэрэгжүүлэгч “Шарын гол” ХК нь 2024 оны уулын ажлын төлөвлөгөө болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллаж төлөвлөгөөнд тусгагдсан бүх ажлыг амжилттай хэрэгжүүлэн, төлөвлөгөөнд тусгагдсан сар бүр тогтмол хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд уурхайн ажилчдын тосгоныг бүрэн тохижуулсан болно.

2.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Техникийн нөхөн сэргээлтийг дотоод овоолгоор 4,8 га, биологийн нөхөн сэргээлт 1,0 га талбайд нийт га талбайд хийхээр төлөвлөсөн боловч 2024 оны 6 сард Нүүрсний уурхайд Тэрбум моды хөтөлбөрийн хүрээнд усалгааны систем болн олон наст ургамал тарьсан .

2024 оны 5 сард уурхайн олборлолтын үйл ажиллагааг эхэлсэн. Эхний сард тунгаах нуур байгуулах, угаан баяжуулах төхөөрөмжийн засварын ажлыг хийж суурилуулж, 5-р сарын 11-нд олборлолт, баяжуулахын үндсэн үйл ажиллагааг эхэлсэн.


Техникийн нөхөн сэргээлт:

2024 онд ашиглалт явагдсан блокийн хэмжээнд хоосон орон зайг бөглөж, технологийн зам хийх, уурхайн баяжуулалтын скруббер байрлуулах тавцан засах, нөөцийн талбай бэлтгэх зэргээр ашиглалт явагдсан орон зайг аль болох түлхүү ашиглах байдлаар сул орон зайд дүүргэлт хийж хэлбэршүүлэн 4,8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Мөн Дулаан шарын голын ирүүлсэн албан бичгийн дагуу 1,0 га талбайд 15.5мян.м3 шороогоор дүүргэлт хийж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

**БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг №04-Уурхайн 2025 онд нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөний дэвсгэр зураг



*Зураг №05-Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын талбайд
2024 онд Техникийн нөхөн сэргээлт хийхээс өмнөх байдал*



Зураг №06-Техникийн нөхөн сэргээлт хийхээс өмнөх



Зураг №07-Техникийн нөхөн сэргээлт хийхээс өмнөх



Зураг №08-Буянтмын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын талбайд Техникийн нөхөн сэргээлт хийсний дараа

БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Үржил, шимт хөрсний овоолго:

Өмнөх жилүүдэд үүсгэсэн үржил шимт хөрсний овоолгыг 3-5м-ээс илүүгүй өндрөөр байгуулж, ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг гүйцэтгэх боломжтой байдлаар байршуулан ажиллаж байна.

2024 онд уулын ажилд 3.37 га талбай хамрагдсан, харин шинээр эвдрэлд оруулсан талбай байхгүй.

Зураг 14. Үржил шимт хөрсийг блокийн баруун захаар байршуулж, анхааруулах тэмдэглэгээ байршуулсан байдал



Хөрс хуулалт, тээвэрлэлт:

Хөрсийг дотоод овоолгод байршуулах нь байгаль орчин болон эдийн засгийн хувьд маш сайн талтай байдаг. Дотоод овоолго хийснээр тээврийн зардлыг багасгах мөн техникийн нөхөн сэргээлтийн зардлыг багасгадаг.

Тиймээс 2024 онд хөрс хуулалтын ажил хийгдээгүй, дотоод овоолго болон нуурын далан хийх зэрэгт ашигласан эфелийн хаягдал галийг ашиглав. Тиймээс ашиглалтын нэг талаас эхлүүлэн дараа дараагийн жилүүдэд /өмнөх жилүүдийн хуулсан хөрсийг/ өмнөх олборлосон орон зайд нөхөн дүүргэх зарчмаар дотоод овоолго үүсгэн ашиглах нь хамгийн оновчтой гэсэн байдлаар төлөвлөгөөнд тусгасны дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.

Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт:

Дулаан шарын ХК-ын албан хүсэлтийн дагуу шарын гол сумын цэвэр ус байгууламжын хамгаалах хүсэлтийн дагуу 1.0 га талбайд бульдозер ашиглан түрэлт хийж, нөхөн дүүргэлт хийсэн.

Дүйцүүлэн хамгаалах-Биоло гийн нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал





ДШГТӨХК- ийн Бохир шугамны уг талбайн хөрсний бохирдолыг цэвэрлэж хар лагийг хусаж авч шимт хөрсөөр хучилт хийж, Царгас согоовор тарьсан боловч 10 дугаар сард сумын төвөөс – Сэлэнгэ аймгийн Баянгол сумруу зам тавих ажил хийгдэж тус нөхөн сэргээлт хийсэн талбайд туслах зам хийж бидэнд мэдэгдэлгүйгээр замын трас татаж эвдрэлд орж нбиологийн нөхөн сэргээлтээр хүлээлгэж өгч чадаагүй .

**БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**2024 онд Буянт хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордын талбайн
Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажилд зарцуулсан зардлын задаргаа**

№	Нөхөн сэргээлт	Талбайн хэмжээ, га	Ажлын хэмжээ, м³	Ажилласан техникууд				Түлш зарцуулалт		Түлшний үнэ, төгрөг		Бусад зардал, төгрөг	Бүгд зардал, төгрөг	Тайлбар	
				Марк	Тоо, ш	Хоног	Цаг	Норм, л/цаг	Нийт зарцуулсан	Нэгж үнэ	Нийт үнэ				
1	Буянт-талбайд Техникийн нөхөн сэргээлт	1.0	9,800.00	Бульдозер	1	3	30	30	900.00	3,690.00	3,321,000.00		3,321,000.00	ДШГТӨХК-ийн цэвэр уны шугам түрж тэгшлэсэн	
				Автоашигч тех/машин	1	1	5	14	70.00	3,690.00	258,300.00	258,300.00			
				Бусад								200,000.00	200,000.00		
				Дүн:	1.0	9,800.00	-	3.00	7.00	71.00	44.70	995.20	11,070.00		3,672,288.00
2	Биологийн нөхөн сэргээлт	10	4,800.00	Экскаватор	1	3	60	32	1,920.00	2,900.00	5,568,000.00		5,568,000.00	шимт хөрс болон өтөг, бууц тээвэрлэж, автоашигчаар тарааж, грейдерээр тэгшилж, 7 хүн 112 хүн.цаг ажилласан	
				Хово	2	3	30	20	600.00	2,900.00	3,480,000.00	3,480,000.00			
				Грейдер	1	1	10	16	160.00	2,900.00	464,000.00	464,000.00			
				тех/машин	2	2	16	0.7	11.20	2,900.00	64,960.00	64,960.00			
				Хүн өдөр	7	2	112					952,000.00			
				Бусад, /үр/								2,649,000.00			
Дүн:	10	30,000	-	13.00	11.00	228.00	68.70	2,691.20	4,816,960.00	13,177,960.00					
3	Дүйцүүлэх-Техникийн нөхөн сэргээлт	0.5	2,614.0	Бульдозер	1	3	36	30	1,080.00	3,690.00	3,985,200.00		1,985,200.00	ДШГТӨХК бохир шугамны бохирдсон хөрсийг хусаж тэгшлэж, биологи хийсэн	
				Автоашигч	1	1	10	14	140.00	3,690.00	516,600.00	516,600.00			
				тех/машин	1	4	64	0.7	44.80	3,690.00	165,312.00	165,312.00			
Дүн:	0.5	2,614.00	-	-	-	-	-	1,264.80	11,070.00	4,667,112.00	-	4,667,112.00			
4	Тэрбүм модны хүрээнд	10	30,000	800 м усалгааны 80 хэмжээтэй труба 1 м труба үнэ*20.000 төг 800м *20.000=16.000.000 13 хаалт *10000төг=130.000 төг 500 м шланг*3000=1.500.000 төг											800 м труба Усалгааны систем зардал
				Дүн:	1.93	1,544.00	-	-	-	-	-	963.20	11,601.00	17,630,000	
БҮГД:		12.17	28,758.00	-	28.00	27.00	425.00	164.10	5,914.40	33,741.00	20,742,344.00	5,128,800.00	39,347,392.00		

Тайлбар:

1

ДШГТӨХК-ийн цэвэр Усны шугам түрж тэгшлэсэн 1.0га, Биологийн нөхөн сэргээлтийн 10 га талбай шимт хөрс бууц түрж тэгшлэх усалгааны системд угсарах ажил хийж гүйцэтгэлээ. ДШГТӨХК бохир шугамны бохирдсон хөрсийг хусаж тэгшлэж, биологи хийсэн

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Овоолгын бүтцийн зүй зохистой төлөвлөлт нь хүчтэй салхи шуурганы үед босох тоосыг тодорхой хэмжээгээр багасгахад нөлөөлсөн.
- Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн үйл ажиллагааны үе шатанд замын гадаргуу болон уурхайн орчны тоосжилт их болдог газруудыг усалгааны машинаар тогтмол услаж байсан.
- Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлэн ажиллаж ирсэн.
- 2024 онд графикийн дагуу Дархан-Уул аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар орчны шинжилгээний лабораториас шинжилгээ хяналт хийлгэсэн.
- Уурхайн үйл ажиллагаа эд явагдаж байгаа үед хур тунасдасгүй үед усны машинаар технологийн зам болон тоос шороо босч болох бүх газруудад усалгааг зориулалтын усны машиныг ашиглан, хөрсийг чийглэж, агаарт дэгдэж болох тоос, тоосонцорыг бууруулж байлаа.

Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Гадаргын болон гүний усанд хамгаалалтын бүс тогтоож хамгаалалтын бүсэд мөрдөх журмыг чанд сахин ажилласан усны хэмжээг гаргаж төлбөр төлсөн.
- Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн хатуу хаягдлаа ялган хаяж байсан.
- Ундны усыг Дулаан шарын гол ТӨХК-ны худгаас хангаж, технологийн усыг Шарын голын нүүрсний уурхайн шүүрлийн усыг 3км урт трубагаар татаж, цэвэр усны санг дүүргэж ашигласан.

Хөрс, ургамал, газарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө шимт хөрсийг 0.2- 0.3 м зузаантайгаар хуулж авна.
- Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалж байсан.
- Үржил шимт ургамлын хөрсийг бохирдуулах, гэмтээхээс сэргийлэх зорилгоор хөрс хуулах ажлын өмнө газрын үржил шимтэй өнгөн хөрсийг хуулж тусгай орон зай бүхий овоолго үүсгэж хадгалан олборлолтын ажил дууссаны дараа уг хөрсийг нөхөн сэргээлтэд хэрэглэж байхаар тусад нь овоолсон.

- Шатах, тослох материалыг Шарын голын нүүрсний уурхайн ШТС-аас зориулалтын тусгай зөвшөөрөл бүхий машинаар зөөвөрлөн хангасан. Техникийн засвар үйлчилгээ, үзлэг хийх, цэнэглэх ажлыг тусгай зассан талбайд хийж гүйцэтгэх буюу нүүрсний уурхайн засварын баазад засварлаж байсан.

Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс:

Ордын ашиглалтын талбай түүний ойр орчимд түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс байхгүй бөгөөд археолгийн хайгуул судалгаа хийлгэсэн болно.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт:

Ажилчдын хотхонд хатуу хог хаягдлын нэгдсэн цэг байгуулсан. Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын менежментийн хэрэгжүүлж ахуйн хатуу хаягдлаа ялган хаяж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан “Тамир Эм” бэлдмэлийг хуваарийн дагуу хэрэглэсэн. Энэ нь Ахуйн бохир усыг цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх ариутгалын бодис ба хортой ба аюултай бодисын хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс бага агууламжтай. Байгаль орчинд хоргүй эм технологийн цуврал бүтээгдэхүүн юм.

Орчны хяналт шинжилгээний ажлын биелэлт:

“Шарын гол” ХК-ийн уурхайн 2024 оны орчны хяналт шинжилгээний ажлыг 5, 8, 10 р сард Ус цаг уур орчны шинжилгээний газар орчны шинжилгээний лабораториор хийж гүйцэтгүүлсэн. Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, агаарын тоосжилт, агаарын бохирдол, хөрсний шинжилгээ хийсэн.

Хөрс, усны шинжилгээг “Геологийн төв лаборатори”-т шинжлүүлсэн болно. Орчны агаарын шинжилгээг агаарын тоосжилтыг хэмждэг DustTrak DRX нэртэй багажаар, агаарын бохирдлыг MX-6 IBRID багажаар хэмжсэн. Шинжилгээний хариуг хавсралтаар оруулав.

Агаарын бохирдлыг хэмжихэд ордын орчим агаарын бохирдол маш бага буюу хүний эрүүл мэндэд хохирол учруулж нөлөөлөхгүй хэмжээгээр байна.


3 цэгээс хөрсний дээж авч шинжилгээнд өгсөн. Хөрсний дээжийн шинжилгээний хариугаар Ph7.94 байгаа нь стандартаас 0.16-ээр бага байна. Ийм учраас биологийн нөхөн сэргээлт хийхдээ ямар бордоо хэрэглэх талаар мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажилласан.

Уурхайн ажилчдын унданд ашигладаг ус нь ундны усны стандарт MNS900-2005-ын стандартыг хангаж байна.

Усны тухай хуульд зааснаар усан сан бүхий газрын эрүүл ахуйн бүсийг 100 м, энгийн хамгаалалтын бүсийг 200 м зайд тогтоосон байдаг бөгөөд хамгаалалтын бүсэд мөрдөгдөх

БУЯНТЫН ХӨНДИЙН АДАГ ХЭСГИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

дэглэмийг чандлан үйл ажиллагаагаа явуулж байгаа нь усны эх үүсвэр бохирдохоос хамгаалж байгаа томоохон ажил юм.



Зураг 22. Ашиглалт явуулж байгаа ил уурхайгаас хөрс, агаар, уснаас улиралд 1 удаа 2-3 цэгээс дээжлэлт авч шинжилгээд хамрууллаа.

Шинжилгээний хариунуудыг хавсралтаар орууллаа

**2024 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗАРЦУУЛСАН
ЗАРДЛЫН ЗАДАРГАА**

№	Зардлын утга	Зарцуулсан зардал, (мян.төг)	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2.0	
2	Техникийн нөхөн сэргээлт	3.8	1.0 га ДШГТӨХК -ийн цэвэр усны шугамны хамгаалалтын бүсийг үед ус эвдсэн эсэхийг түрж тэгшлэсэн
3	Биологийн нөхөн сэргээлт	13.1	10 га талбайд шимт хөрс бууц хучилт хийх, түрж тэгшлэх ажил хийгдсэн
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	4.6	0.5 га ДШГТӨХК-ийн бохир шугамнаас үүдэлтэй хөрсний бохирыг хусаж цэвэрлэж шимт хөрсөөр хучилт хийж, царгас тарьж нөхөн сэргээлтийн ажил хийсэн.
5	“Тэрбум мод тарих” хөтөлбөрийн хүрээнд	17.6	Тэрбум модны хүрээнд мод тарьсан талбайд усалгааны систем мөн шимт хөрс хучиж тэгшлэх ажил хийсэн
6	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-	2024 онд түүх соёлын өвийг хамгаалсан, дурсгалт зүйлс илрээгүй тул тодорхой мөнгөн хөрөнгө зарцуулж, ямар нэгэн ажил хийгдээгүй.
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-	2022 онд нэг удаа тээвэр хийж, гэрээний дагуу сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг ланфилийн аргаар буулж, түрсэн. Энэ ажлын хүрээнд зарцуулсан зарлыг компанийн хэмжээнд хийгдсэн тул үйл ажиллагааны зардалд оруулсан.
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2.0	Хөрс, агаар, усны шинжилгээнд зарцуулсан. Зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй.
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1.0	Тухайн талбайд байгаль орчны аудитын тайлан, ус ашиглах дүгнэлт гаргуулах зэрэг ажлуудад зарцуулсан.
10	Нийгмийн хариуцлагын хүрээнд Шарын гол сумын засаг даргын тамгын газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний дагуу ажиллаж ирсэн.	-	Компанийн хэмжээнд зардал гаргаж, гэрээний дагуу ажилладаг тул алтны хэсгийн зардалд тусад нь оруулдаггүй.
Нийт дүн:		46 164.1	Зарцуулсан зардлын нэгтгэсэн дүн

Буянтын хөндийн адаг хэсгийн алтны үүсмэл шороон ордыг бүрэн олборлосон талбайд нөхөн сэргээх ажлыг шат дараалалтайгаар хийж, уурхайн хаалтын ажилд бэлтгэх төлөвлөгөөтэй байгаа. ТЭЗҮ нь 2022 онд 5 жилийн хугацаатайгаар хийгдсэн.

ДҮГНЭЛТ

“Шарын гол” ХК-ийн ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дархан-Уул аймгийн Шарын Гол сумын нутагт MV-001498 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн талбайд оршино. 2024 онд 5-10 сарын турш ажиллаж, хөрс хуулалтын ажил хийж, 42.5мян.м³ элс угаасан.

Техникийн нөхөн сэргээлтийг 1.0 га Дулаан шарын голын хүсэлтийн дагуу цэвэр усны шугамны хамгаалалтын бүсийн үер ус эвдсэн эсэхийг түрж тэгшлэсэн. 2024 онд 10 га талбайд шимт хөрс, бууц хучилт хийх, түрж тэгшлэх ажил хийгдсэн. Дүйцүүлэнгээр 0.5 га ДШГТӨХК-ийн бохир шугамнаас үүдэлтэй хөрсний бохирыг хусаж цэвэрлэж шимт хөрсөөр хучилт хийж, царгас тарьж нөхөн сэргээлтийн ажил хийсэн.

Тэрбум модны хүрээнд мод тарьсан талбайд усалгааны систем мөн шимт хөрс хучиж тэгшлэх ажил хийсэн

Уурхайн ажилчдын хотхоныг тохижуулж эрүүл ахуйн болон орчны эрүүл ахуйн стандартуудыг мөрдөж ажиллалаа. 2024 онд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайгаас өнгөн хөрсний дээжлэлтийг авч хөрсний ялзмагийн хувь, уусмалын орчин, хөрсний ширхэгийн бүтцийг тогтоосны дараа тохирох ургамлыг сонгон биологийн нөхөн сэргээлтийг 2025 онуудад хийх ба хэрэв хөрсийг баяжуулж шаардлагатай бол эрдэс болон шим бордоо хэрэглэх зэрэг арга хэмжээ авна. Манай уурхай нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнийхөө дагуу байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажлуудаа төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж ажиллахыг нэн тэргүүний зорилтоо болгон ажиллаж байна.